

### АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

#### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Говьсүмбэр аймгийн Байгаль орчин,  
аялал жуулчлалын газар

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Аялал жуулчлал, тусгай  
хамгаалалттай газар нутаг, сургалт  
сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-5

Ажлын цаг:

Ажлын: өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 3-р баг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн нөхцөл

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

#### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгаль орчныг хамгаалах бодлого, хууль тогтоомжийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэх, мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлж гүйцэтгэлийн үр дүнг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын өмнө хариуцна.

<u>Албан тушаалын зорилт:</u>			
<p>1.Орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх, тусгай хамгаалалттай газар нутгийн өргөтгөх, үзэл баримтлал, бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах.</p> <p>2.Байгаль хамгаалах сайн дурын иргэдийн бүлэг, нөхөрлөлүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хариуцах, сургалт сурталчилгаа зохион байгуулах.</p> <p>3.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх.</p>			
Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх– Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;	Аялал жуулчлал хөгжих нөхцөл бүрдэж, жуулчдын тоо, аялал жуулчлалын салбараас орох орлого нэмэгдсэн байна	Г
	2.Салбарын үйл ажиллагааг сурталчлан таниулах;		Г
	3.Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ эрхлэгчдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;		Г
	4.Орон нутагт аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг сайжруулах, сургалт, судалгааны ажлыг зохион байгуулах;	Үйлчилгээний, чанар стандарт хангагдаж, аяллын бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн байна.	Г
	5.Орон нутагт аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, сум орон нутаг аяллын маршрут боловсруулж зах зээлд нийлүүлэхэд нь мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, шинэ бүтээгдэхүүн бий болгох, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, зөвлөгөө дэмжлэгээр хангах;		Г
	6.Орон нутгийн аялал жуулчлалын мэдээллийн санг бий болгох, статистик мэдээ гаргах.		Г
	1.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, холбогдох		Г



2 дугаар зорилтын хүрээнд	журам, тогтоол, шийдвэрийг аймгийн хэмжээнд сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хуулийн дагуу хяналт тавина;	Хамгаалалтын менежментийн төлөвлөгөө хэрэгжсэн байна.	
	2.Тусгай хамгаалалттай газар нутаг дээрх аливаа аж ахуйн болон иргэдийн үйл ажиллагаанд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хяналт тавих, илэрсэн зөрчлийг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах, шийдвэрлүүлэх ажлыг хамтран хэрэгжүүлнэ;		Г
	3.Тухайн газар нутгийг улс, орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан тухай сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрийг хуульд нийцсэн эсэх, Ашигт малтмалын газарт хүргүүлж бүртгүүлэх, аймгийн кадастрын зураглалд оруулсан байхад анхаарч, мэдээллийн сангийн ажилтантай хамтран ажиллана;		Г
	4.Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдээр сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах жилийн төлөвлөгөө гарган сургалт сурталчилгааны ажлуудыг зохион байгуулж иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлнэ;	Зохион байгуулсан сургалтын тоо, оролцсон иргэдийн тоо	Г
	5.Байгаль орчны болон орон нутгийн бусад вэб сайтуудтай холбоо тогтоон хамтран ажиллах		Г
	6.Эко сургууль, экоклубуудын үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах.		Г
	1.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөн хэрэгжүүлж тайлагнах;	Төлөвлөгөөний зорилт хангагдсан байна.	Г



3 дугаар зорилтын хүрээнд	2. Удирдлагыг өөрийн эрхэлсэн асуудлын чиглэлээр шаардлагатай мэдээллээр хангаж, арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх;	Мэдээллээр хангасан байна.	Г
	3. Өөрийн эрхлэх асуудлын хүрээний бодлогын баримт бичгийн тайлан мэдээг хугацаанд гаргаж, тайлагнах;	Хугацаанд нь тайлагнасан байна.	Г
	4. Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;	Журам, дүрэм, стандарт хэрэгжсэн байна.	Г
	5. Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг шуурхай биелүүлэх, эргэн тайлагнах;	Үүрэг даалгавар хэрэгжсэн байна.	Г
	6. Өөрийн хариуцсан салбарын хүрээнд иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, хариуг хүргүүлэх;	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	Г
	7. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хууль тогтоомжинд заасан бусад чиг үүрэг бүрэн хэрэгжсэн байна.	Г

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	
Мэргэжил	Аялал жуулчлалын менежмент /041304/, олон улсын харилцаа /022204/, аялал жуулчлал /101501/, газар зүй /053202/.	
Мэргэшил	Төрийн албаны мэргэшүүлэх болон албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэргэжлийн чиглэлээр богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх.	
Туршлага	Төрийн албанд 2-оос доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- судалгааны арга зүйн мэдлэгтэй байх;</li> <li>- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх;</li> <li>- нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах;</li> <li>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;</li> <li>- бусад.</li> </ul>




	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх;</li> <li>- хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах;</li> <li>- шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх;</li> <li>- өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх;</li> <li>- аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх;</li> <li>- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг сахих;</li> <li>- ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх;</li> <li>- хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх;</li> <li>- бүтээлч, санаачлагатай ажиллах;</li> <li>- бусад.</li> </ul>
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх;</li> <li>- багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх;</li> <li>- багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах;</li> <li>- үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>- хамт олонч сэтгэлгээтэй, зэрэг уур амьсгалыг дэмждэг байх;</li> <li>- нээлттэй, шударга байх;</li> <li>- бусад.</li> </ul>
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх,</li> <li>- зарчимч, тууштай, ажил хэрэгч байх;</li> <li>- шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх;</li> <li>- хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх;</li> <li>- албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх;</li> <li>- компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;</li> <li>- төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх;</li> <li>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх.</li> </ul>

#### IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга.





<p>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: Байхгүй.</p>	<p>Бусад харилцах субъект:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага</li> <li>- Аймгийн Засаг даргын Тамгын газрын асуудал хариуцсан мэргэжилтэн</li> <li>- Сум багийн Засаг дарга</li> <li>- Улсын байцаагчид</li> <li>- Тухайн орон нутгийн аж ахуй нэгж, байгууллага,</li> <li>- Өөрийн хариуцсан чиглэлийн дагуу төрийн бус байгууллага, дотоод, гадаадын төслийн байгууллагуудтай хамтран ажиллах</li> <li>- Иргэд, хуулийн этгээд</li> </ul>
--	---

**V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

<p>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</p>	<p>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</p>
<p>Албан тушаал: ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОХИРДОЛ, БАЙГАЛИЙН ГАМШИГ, ГАЗРЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН</p> <p>..... С.СУВДМАА</p> <p>20... оны ... дугаар сарын ... -ны өдөр</p>	<p>Байгууллагын нэр: ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ</p> <p>Шийдвэрийн огноо: 19 11 04</p> <p>Дугаар: 244</p>

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

<p>Байгууллагын нэр: БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР</p> <p>Шийдвэрийн огноо: 2019.11.18</p> <p>Дугаар: 1124</p> <p>(тамга/тэмдэг)</p> <p>ДАРГА  Д.МӨНХ-ЭРДЭНЭ</p> <p>2019 оны 11 дугаар сарын 18 -ны өдөр</p>	
--	---